

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/62/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 01/75
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН
АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.ТӨМӨРХУЯГ
ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Засгийн газрын хувь оролцоо /ээздийн өмч/ нэмэгдсэн шалтгаан нь тайлант онд шилжүүлэн авсан газар эзэмших эрхийн гэрчилгээ, газрын суурь үнэ болох 51,450.0 мянган төгрөгийг хүлээн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас Чонын ан ав зохион байгуулах зардалд 10,500.0 мянган төгрөг, аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээний зардалд 2,100.0 мянган төгрөгийг Хөвсгөл аймгийн Сүлд шатрын холбоонд олгосон, сургалт семинар хоол үдийн цайны зардалд 19,388.0 мянган төгрөгийг зарцуулж төсвийн үр ашгийг бууруулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн ИТХ-ын ажлын албаны дарга нь аймгийн ИТХ-ын даргаар 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө батлуулан хэрэгжүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6724040170

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,684,372.00	15,056,427.00
33	АВЛАГА	00.00	202,055.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	202,055.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,684,372.00	14,854,372.00
354	Хангамжийн материал	13,684,372.00	14,854,372.00
35410	Бичиг хэргийн материал	1,959,256.00	1,679,256.00
35420	Аж ахуйн материал	1,905,630.00	3,355,630.00
35430	Сэлбэг хэрэгсэл	692,200.00	692,200.00
35450	Барилгын засварын материал	241,000.00	241,000.00
35470	Бусад хангамжийн материал	8,886,286.00	8,886,286.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	122,444,773.79	275,016,155.91
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	122,444,773.79	275,016,155.91
392	Биет хөрөнгө	120,127,412.55	222,139,767.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,587,620.00	3,587,620.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,195,873.45	-1,494,841.81
39203	Авто-тээврийн хэрэгсэл	63,355,556.00	199,980,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-19,285,185.36	-83,783,333.29
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	61,335,550.00	94,740,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,640,252.92	-23,906,563.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,430,647.23	29,345,028.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24,160,648.95	-17,878,742.65
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,000,000.00	24,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-300,000.00	-2,450,000.00
393	Биет бус хөрөнгө	2,317,361.24	52,876,388.84
39301	Програм хангамж	2,941,667.00	2,941,667.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-624,305.76	-1,515,278.16
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	51,450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	136,129,145.79	290,072,582.91
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	80,968.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	80,968.00	00.00
413	Өглөг	80,968.00	00.00
4136	Бусад өглөг	80,968.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	80,968.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	136,048,177.79	290,072,582.91
51	Засгийн газрын хувь оролцоо	136,048,177.79	290,072,582.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	134,621,105.00	186,071,105.00
51101	Өмч: - төрийн	134,621,105.00	186,071,105.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,427,072.79	104,001,477.91
51210	Өмнөх үеийн үр дүн	1,427,072.79	1,427,072.79
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	102,574,405.12
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	136,129,145.79	290,072,582.91

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,276,112,600.00	1,683,942,266.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,500,000.00	145,818,666.72
120	Нийтлэг татварын бус орлого	6,500,000.00	145,818,666.72
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,500,000.00	145,818,666.72
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,500,000.00	145,818,666.72
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,269,612,600.00	1,538,123,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	392,597,000.00	307,922,000.00

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00	3,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	877015600.00	1230201600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	877,015,600.00	1,230,201,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,262,416,251.35	1,532,171,572.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,262,416,251.35	1,532,171,572.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	872,791,559.64	1,177,574,263.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155,070,943.99	306,074,968.47
210101	Үндсэн цалин	113,350,627.99	179,365,912.30
210102	Нэмэгдэл	21,266,452.00	68,751,265.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,365,000.00	23,680,000.00
210104	Урамшуулал	10,088,864.00	34,277,790.45
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,628,260.61	38,259,371.20
210201	Тэтгэврийн даатгал	13,398,619.18	26,016,372.41
210202	Тэтгэмжийн даатгал	1,576,316.11	3,060,749.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,240,886.74	2,448,599.70
210204	Ажилгүйдлийн даатгал	310,221.70	612,149.95
210205	Эрүүл мэндийн даатгал	3,102,216.88	6,121,499.45
2104	Хангамж, бараа материалын зардал	22,254,834.32	38,280,281.40
210401	Бичиг хэрэг	980,000.00	3,940,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,103,300.00	24,239,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,609,384.32	3,602,781.40
210404	Ном, хэвлэл	96,000.00	576,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	466,150.00	5,921,600.00
2105	Нормативд зардал	215,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	215,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,407,000.00	9,652,400.00
210604	Урсгал засвар	10,407,000.00	9,652,400.00
2107	Томилолт, зочны зардал	6,194,500.00	18,700,000.00
210702	Дотоод албан томилолт	6,194,500.00	18,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	568,350,788.00	339,875,022.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	567,634,320.00	336,918,554.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,440,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,000.00	138,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,468.00	134,468.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	1,200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,670,232.72	426,732,220.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,418,000.00	330,980,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,048,800.00	33,797,280.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,203,432.72	61,954,300.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	389,624,691.71	354,597,308.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	382,263,200.00	319,622,980.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,205,400.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	372,057,800.00	319,622,980.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,361,491.71	34,974,328.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,361,491.71	34,974,328.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	13,696,348.65	151,770,694.34
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	48,934,863.27	49,196,289.22
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	48,934,863.27	49,196,289.22
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-48,934,863.27	-49,196,289.22
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-35,238,514.62	102,574,405.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,269,612,600.00	1,538,123,600.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,269,612,600.00	1,538,123,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	392,597,000.00	307,922,000.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,597,000.00	00.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,000,000.00	3,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	360,000,000.00	304,922,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	877,015,600.00	1,230,201,600.00	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	877,015,600.00	1,230,201,600.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,210,393,900.00	1,471,670,295.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,210,393,900.00	1,471,670,295.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	820,769,208.29	1,117,072,986.07	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	155,070,943.99	306,277,023.47	
210101	Үндсэн цалин	113,350,627.99	179,567,967.30	
210102	Нэмэгдэл	21,266,452.00	68,751,265.72	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,365,000.00	23,680,000.00	
210104	Урамшуулал	10,088,864.00	34,277,790.45	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,548,459.98	38,259,371.20	
210201	Тэтгэврийн даатгал	13,398,619.18	26,016,372.41	
210202	Тэтгэмжийн даатгал	1,496,515.48	3,060,749.69	
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,240,886.74	2,448,599.70	
210204	Ажилгүйдлийн даатгал	310,221.70	612,149.95	
210205	Эрүүл мэндийн даатгал	3,102,216.88	6,121,499.45	
2104	Хангамж, бараа материалын зардал	22,596,684.32	39,730,281.40	
210401	Бичиг хэрэг	1,020,000.00	3,940,000.00	
210402	Тээвэр, шатахуун	17,103,300.00	24,239,900.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,609,384.32	3,602,781.40	
210404	Ном, хэвлэл	96,000.00	576,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	768,000.00	7,371,600.00	
2105	Нормативт зардал	215,000.00	00.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	215,000.00	00.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,400,000.00	9,652,400.00	
210604	Урсгал засвар	11,400,000.00	9,652,400.00	
2107	Томилолт, зочны зардал	6,194,500.00	18,700,000.00	
210702	Дотоод албан томилолт	6,194,500.00	18,700,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	570,276,820.00	339,956,030.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	569,560,352.00	336,999,562.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	1,440,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	138,000.00	138,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,468.00	134,468.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	1,200,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	35,466,800.00	364,497,880.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,418,000.00	330,980,600.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,048,800.00	33,517,280.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	389,624,691.71	354,597,308.93	
2132	Бусад урсгал шилжүүлэг	382,263,200.00	319,622,980.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	10,205,400.00	00.00	

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	372,057,800.00	319,622,980.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	7,361,491.71	34,974,328.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,361,491.71	34,974,328.93
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>59,218,700.00</u>	<u>66,453,305.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	59,218,700.00	66,453,305.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	59,218,700.00	66,453,305.00
2200	Дотоод эх үүсвэрээр	59,218,700.00	66,453,305.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	59,218,700.00	66,453,305.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-59,218,700.00</u>	<u>-66,453,305.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,621,105.00	198,417.50	36,467,169.91	171,286,692.41
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	198,417.50	198,417.50
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	134,621,105.00	198,417.50	36,665,587.41	171,485,109.91
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,621,105.00	198,417.50	36,665,587.41	171,485,109.91
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	134,621,105.00	198,417.50	36,665,587.41	171,485,109.91
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	134,621,105.00	00.00	1,427,072.79	136,048,177.79
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	51,450,000.00	00.00	00.00	51,450,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	102,574,405.12	102,574,405.12
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,071,105.00	00.00	104,001,477.91	290,072,582.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,230,201,600.00	1,195,227,271.07	34,974,328.93	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,230,201,600.00	1,195,227,271.07	34,974,328.93	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,190,477,500.00	1,155,604,291.07	34,873,208.93	97.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	327,555,700.00	306,277,023.47	21,278,676.53	93.5
210101	Үндсэн цалин	203,422,800.00	179,567,967.30	23,854,832.70	88.3
210102	Нэмэгдэл	68,387,900.00	68,751,265.72	-363,365.72	100.5

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,120,000.00	23,680,000.00	7,440,000.00	76.1
210104	Урамшуулал	24,625,000.00	34,277,790.45	-9,652,790.45	139.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,944,400.00	38,259,371.20	2,685,028.80	93.4
210201	Тэтгэврийн даатгал	27,842,200.00	26,016,372.41	1,825,827.59	93.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,275,600.00	3,060,749.69	214,850.31	93.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,620,400.00	2,448,599.70	171,800.30	93.4
210204	Ажилгүйдлийн даатгал	655,100.00	612,149.95	42,950.05	93.4
210205	Эрүүл мэндийн даатгал	6,551,100.00	6,121,499.45	429,600.55	93.4
2104	Хангамж, бараа материалын зардал	40,447,500.00	39,730,281.40	717,218.60	98.2
210401	Бичиг хэрэг	3,940,000.00	3,940,000.00	00.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	24,239,900.00	24,239,900.00	00.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,320,000.00	3,602,781.40	717,218.60	83.4
210404	Ном, хэвлэл	576,000.00	576,000.00	00.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,371,600.00	7,371,600.00	00.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	54,656,000.00	47,916,400.00	6,739,600.00	87.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	45,000,000.00	38,264,000.00	6,736,000.00	85.0
210604	Урсгал засвар	9,656,000.00	9,652,400.00	3,600.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	19,000,000.00	18,700,000.00	300,000.00	98.4
210702	Дотоод албан томилолт	19,000,000.00	18,700,000.00	300,000.00	98.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	337,356,600.00	334,223,335.00	3,133,265.00	99.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	334,400,100.00	331,266,867.00	3,133,233.00	99.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,440,000.00	1,440,000.00	00.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	138,000.00	138,000.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,500.00	134,468.00	32.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	00.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200,000.00	1,200,000.00	00.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	370517300.00	370497880.00	19,420.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	337,000,000.00	336,980,600.00	19,400.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	33,517,300.00	33,517,280.00	20.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39724100.00	39622980.00	101,120.00	99.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,724,100.00	39,622,980.00	101,120.00	99.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,724,100.00	39,622,980.00	101,120.00	99.7

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,230,201,600.00	1,195,227,271.07	34,974,328.93	97.2
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,230,201,600.00	1,195,227,271.07	34,974,328.93	97.2
132001	Орон нутгийн төсвөөс	1,230,201,600.00	1,195,227,271.07	34,974,328.93	97.2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10.00	10.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Гүйцэтгэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		307,922,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		307,922,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		27,922,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		27,922,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		27,922,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		280000000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		280,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		280,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		307922000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		307,922,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		304,922,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 220,586.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Илэрсэн зөрчилд 85,986.4 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 40,000.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж, 82,000.0 мянган төгрөгийн зөрчилд хариуцлага тооцуулах 1 албан шаардлагыг өгсөн. Үүнээс материаллаг хэмжээний зөрчил 12,600.0 мянган төгрөг, материаллаг бус 85,986.4 мянган төгрөгийн зөрчил байна.

5.1 Төлбөрийн акт

Төсвийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой илэрсэн дараах зөрчилд төлбөрийн акт тогтоосон: Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас аймгийн аварга шалгаруулах шатрын тэмцээний зардалд 2,100.0 мянган төгрөгийг Хөвсгөл аймгийн Сүлд шатрын холбоонд олгосон байна. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 25 дугаар зүйлийн 25.10."Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" гэсэн заалтууд болон "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй тул **төлбөрийн акт тогтоохоор** шийдвэрлэсэн.
- Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Чонын ан ав зохион байгуулах зардалд 10,500.5 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. Үүнд: Цагаан-Үүр ИТХ-д 3,000.0 мянган төгрөг, Чандмань-Өндөр сумын ИТХ-д 2,500.0 мянган төгрөг, Тариалан ЗДТГ-т 5,000.0 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн байна. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт

болон “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй тул **төлбөрийн акт тогтоохоор** шийдвэрлэсэн.

5.2 Албан шаардлага

Байгууллагын төсвөөс үр ашиггүй зардал гаргаж төсөв зарцуулсан дараах зөрчилд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн. Үүнд:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 12,294.0 мянган төгрөгийг сургалтын хоолонд зарцуулж Хөвсгөл центр ХХК-д 9,150.0 мянган төгрөг, Хөвсгөл өргөө ХХК-д 3,144.0 мянган төгрөгийн төлбөрийг тус тус шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", гэсэн заалт болон “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй.
- Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхжуулах бүсчилсэн сургалтыг зохион байгуулж нийт 45,311.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Сумдын ИТХ-ын төлөөлөгчид нь тухайн сумдын ИТХ-ын төсвөөс тойрогт ажиллах үйл ажиллагааны зардал болон чадавхжуулалтын зардлаа авсан байхад дахин сургалтад хамруулж байгаа нь зардал давхардаж байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан "иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын хавсралтаар баталсан жишигтэй нийцэхгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй.
- Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны албан хаагчдыг сургалтад хамруулж нийт 12,070,000 төгрөг зарцуулсан. Үүнээс: Сургалтад оролцсон алба хаагчдыг хоолонд оруулж хоолны зардалд 8,480.0 мянган төгрөгийг Хөвсгөл өргөө ХХК-д шилжүүлсэн, Хөвсгөл Тэвхэн ХХК-д үдийн цайны печень, кофены зардалд 614.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй.
- Барут хотын хамтын ажиллагааны хүрээнд байрны зардалд 3,191.0 мянган төгрөг, хоолны зардалд 14,292.0 мянган төгрөг нийт 23,483.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй.
- Татварын мэргэшсэн зөвлөхийн нэмэгдлийг нягтлан бодогчид сар бүр 15 хувиар тооцож нийт 1,804.1 мянган төгрөгийг олгосон байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн "3.1.7. "мэргэшсэн нягтлан бодогч" гэж мэргэшсэн нягтлан бодогчийн эрх авсан мэргэжлийн нягтлан бодогч, санхүүч, эдийн засагчийг хэлнэ", 23 дугаар зүйлийн 23.1. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын шийдвэрээр нягтлан бодох бүртгэлийн ажилтанд мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгож болно" Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4. "татварын мэргэшсэн зөвлөх" гэж татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх авсан, татварын итгэмжлэгдсэн хуулийн этгээдэд ажиллах татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг; 3.1.5. "татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч" гэж татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хувь хүнийг" хэлнэ гэсэн заалтууд болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тус байгууллагын төсөвт Уран дөш хүүхдийн зусланд 40,000.0 мянган төгрөгийг санхүүжилт олгох төсөвтөө тусган батлуулж олгосон нь тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй зардал байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6. "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага.

Өмнөх аудитаар тогтоосон 82,000.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй, төсвөөс үр ашиггүй зардал гаргасан зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Дээрх зөрчил нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1."Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.1."төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" гэсэн заалтууд болон "Эрх үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээлээгүй 5, хугацаа хоцроож мэдээлсэн 13 мэдээлэл байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2."хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.4.8."бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн ил тод байдлыг хангаж мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн, үнэн зөв мэдээлж ажиллах.

2. Төсвийн төлөвлөлт хуваарилалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус байгууллагын төсөвт Уран дөш хүүхдийн зусланд 40,000.0 мянган төгрөгийг санхүүжилт олгох төсөвтөө тусган батлуулж олгосон нь тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй зардал байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6."тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй хөтөлбөр арга хэмжээнд төсөв батлуулж санхүүжилт олгохгүй байх.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	10	220,586.4	1	10,600.0	1	85,986.4	1	40,000.0	1	82,000.0
Дүн	10	220,586.4	1	10,600.0	1	85,986.4	1	40,000.0	1	82,000.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй	1				1	
Дүн	1				1	